



ТӨРИЙН САНХҮҮ, ТӨСВИЙН ХЯНАЛТЫГ ХАРААТ БУСААР ХЭРЭГЖҮҮЛЖ, ХАРИЛЦАГЧ
ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ИРГЭДИЙН АМЬДРАЛЫГ САЙЖРУУЛНА



1

Хууль, эрх зүйн үндэслэл


2

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудит



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН САЛБАР



Төрийн аудитын тухай хууль:

6.3.1.

Шалгагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх.

20.5.

Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

39.1.

Энэ хуулийн 11.2-т заасан аудитыг гүйцэтгэхэд төрийн аудитын байгууллагын албан хаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, аливаа дарамт, шахалт үзүүлсэн, хууль бус нөлөөллийн талаар нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.

42.2.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН САЛБАР

Санхүүгийн тайлангийн аудитын зорилго

Санхүүгийн тайлангийн
хэрэглэгчдийн итгэл
үнэмшлийг нэмэгдүүлэх

Санхүүгийн тайланг зохих
стандарт, шаардлагын дагуу
бэлтгэсэн эсэх талаар
хараат бус дүгнэлт гаргах

Шалгагдсан байгууллагын санхүү,
нягтлан бодох бүртгэл, тайлагнал
шаардлагад нийцэж байгаа эсэх талаар
үндэслэлтэй баталгаа, мэдээллээр хууль
тогтоох байгууллагыг хангах

**Төрийн мөнгөний үнэ цэнийг
сайжруулахад чиглэнэ.**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТУЛГУУР ЗАРЧИМ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН САЛБАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЦАГЛАБАР



Төсвийн тухай хууль
8.9.1, 8.9.8, 8.10.1



ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ



ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

1-р сарын 25
2-р сарын 25



2-р сарын 15
3-р сарын 15



3-р сарын 5
3-р сарын 25



4-р сарын 5
4-р сарын 25



5-р сарын 10
6-р сарын 10



ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ,
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН НЭГЖИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ



ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ,
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСТАЙ САНГИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ



ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН
НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН





Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэснээр дараах давуу талууд бий болдог.

Төрийн аудитын байгууллагын хувьд

- Шалгагдагч байгууллага түүний орчны талаар болон үйл ажиллагаанд гарсан өөрчлөлт, тухайн тайланд онд хэрэгжүүлсэн бодлого чиглэлийн талаар ойлголтыг олж авах;
- Санхүүгийн тайланд тусгагдсан бүх мэдээллээс эрсдэл өндөртэй, алдаа зөрчил гарах магадлалтай ажил гүйлгээ, дансны үлдэгдэл болон тодруулгыг ялган сонгож, тэдгээрийг шалгахын тулд ямар аудитын горим, сорилыг, хэрэгжүүлэхийг урьдчилан төлөвлөх;
- Цаг хугацаа хэмнэх, аудитыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх;

Шалгагдагч байгууллагын хувьд

- Тухайн төсвийн жилд гарсан алдаа, зөрчлийг залруулах боломж бүрдэнэ.
- Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтэд нөлөөлөх материаллаг алдаа, зөрчлийн хэмжээ буурна.





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 2025 ОНЫ ЗАВСРЫН АУДИТЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН САЛБАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/17

Арвайхээр сум

Санхүүгийн тайлангийн завсрын
аудитын хуваарь батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторов баталсан аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны санхүүгийн тайлангийн завсрын аудит хийх байгууллага, хариуцан гүйцэтгэх аудиторуудын хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Шалгагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж, гүйцэтгэхийг ахлах аудитор (Б.Эрдэнэцэцэг), санхүүгийн аудитын багт тус тус үүрэг болгосугай.

3. Аудитын үе шатны ажлыг хянан удирдаж ажиллахыг аудитын менежер (П.Хорлоосүрэн)-д даалгасугай.



О.БАТЖАРГАЛ

D:\Auditin gazar\Baiguullagiin dotood barimf\Tushaal

6225010049

Аудитад хамрагдагч

1

Боловсролын
газар

33

Ерөнхий
боловсролын
сургууль

46

Сургуулийн өмнөх
боловсролын
байгууллага

73

Байгууллагад
алдаа, зөрчил
илэрсэн

Аудитын илрүүлэлт

Залруулга

25

алдаа

158.8

сая төгрөг

Зөвлөмж

3

зөрчил

17.1

сая төгрөг

Төлбөрийн акт

69

зөрчил

189.9

сая төгрөг

Албан шаардлага

46

зөрчил

233.8

сая төгрөг

НИЙТ

143

алдаа, зөрчил

599.5

сая төгрөг



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЗАЛРУУЛГА (ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАР)

ЗАЛРУУЛГА

Мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардал нь үндсэн хөрөнгийн тодруулга тайланд бүртгэгдсэн худалдан авсан хөрөнгийн дүнтэй зөрүүтэй тайлагнагдсан.

Үр дүнгийн тайланд хүүхдийн үдийн цайны зарцуулалтыг дутуу бүртгэсэн

Бусад үндсэн хөрөнгөнд ном бүртгэсэн, өөрөөр хэлбэл хөрөнгийн ангиллыг буруу хийж, дансны зохистой ангилал алдагдсан

Авлага, өглөг дутуу бүртгэсэн

158,758,599.85 төгрөг



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЗӨВЛӨМЖ (ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАР)



Дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийн хоолны зардлыг тооцохдоо насны ангилал тус бүрээр нэг хүүхэд-өдөрт ногдох норматив зардлын тооцоог хийж, түүнийг албан ёсоор баталгаажуулалгүй



Тус сургуулийн дотуур байранд бусад сургуулиас байрлаж байгаа **28** сурагчийн дотуур байрны хүүхдийн хоолны зардал **27,680,400.0** төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлээгүйн улмаас **III** улирлын байдлаар **17,046,801.0** төгрөгийн хүнсний бүтээгдэхүүний өглөгтэй гарсан байна.



Дотуур байрны хүүхдийн хоолны материалыг шаардах хуудсаар олгохдоо бага, дунд, ахлах ангиар ялган бүртгээгүй байна.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЛБАН ШААРДЛАГА (ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАР)

Аудитын явцад хүнсний материалын зарцуулалтын тооцоолол хийж орлого авсан, зарцуулсан материалын үлдэгдлийн тулгалт хийхэд хүнсний материалын тайлангийн үлдэгдэл зөрүүтэй бөгөөд бараа материалын дэлгэрэнгүй тайланд үлдэгдэл буруу илэрхийлэгдсэн байна.

Үдийн хоолны зардлаас аж ахуйн материал худалдан авсан.

Дотуур байрны хүүхдийн хоолны норматив зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Дотуур байрны хүүхдийн хоолны нормативыг нэг хүүдэд дутуу олгосон, бага дунд ахлах ангиар ялгаж нормативыг баримтлаагүй, Үдийн хоолны нормативыг дутуу олгосон байна.

Хичээл үйлдвэрлэлийн зардлаас худалдаж авсан үндсэн хөрөнгийг багш нарт шууд шаардахаар зарлагдсан.

Захирлын нэрэмжит шагнал олгож төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Үдийн хоолны нэг хүүхдийн норматив зардлыг дутуу олгосон, хөгжлийн бэрхшээлтэй 2 бүлгийн 41 хүүхэд суралцдаг боловч үдийн хоолыг 3000 төгрөгөөр тооцож олгоогүй байна.

Албан томилолтын зардлыг бодож олгохдоо томилолтын хуудсанд ирсэн буцсан он сар өдөр болон хаана ажилласан нь тодорхойгүй зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад томилолт олгосон, хоолны мөнгийг томилолтын хоолны зардалтай давхардуулан олгосон байна.

Бараа үйлчилгээний бусад зардлаас үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Урсгал засварын зардлаас үндсэн хөрөнгө худалдан авсан.

Завсрын аудит хийх явцад түүврээр үндсэн хөрөнгийн тооллогыг хийж үзэхэд машин тоног төхөөрөмжийн дансанд зөрүү нэртэй, нэр төрлөөр нь задалж бүртгээгүй бөөн дүнгээр нь бүртгэсэн байна.

Хүнсний материалыг их хэмжээгээр худалдан авч нөөцлөн эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон. Төсвийн хөрөнгөнд үр ашиггүй хандсан байна.

Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодсон хуудас байхгүй шатахуун зарцуулсан байна.

Анхан шатны баримтын бүрдэл дутуу.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдэд нэмэгдэл хөлс олгох тухай цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгчийн 2025 оны 02 сарын 17-ны өдрийн Б/06 тоот тушаалаар 4 гишүүнтэй зөвлөл байгуулж дарга, гишүүдэд 10 хувиар нэмэгдэл олгосон.

Гэрэл цахилгааны зардлаас аж ахуйн материалын зардалд зарцуулсан байна.

Үдийн хоолны нэг хүүхдийн норматив зардлыг дутуу олгосон байна.

Хүчингүй болсон БШУС-ын тушаалыг үндэслэл болгон Хархорин суманд багш нарын туршлага судлах зардлыг мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас зарцуулсан.

Хүүхдийн хоолны нэг өдрийн хоолны норматив зардал, үдийн хоолны нэг хүүхдийн норматив зардлыг дутуу олгосон байна.

Хүнсний материал худалдан авахдаа босго үнээс доош болгон хувааж шууд гэрээ байгуулсан байна.

Бичиг хэргийн, аж ахуйн материалын орлого зарлагын баримт дутуу, эд хариуцагч тайлан гаргаагүй байна.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ТӨЛБӨРИЙН АКТ (ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАР)



188,520,410.3 төгрөгийн төлбөрийн акт

Балансын урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай
давхардуулан олгосон байна.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛ (ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАР)

	2023 ОН		2024 ОН	
ТӨЛБӨРИЙН АКТ	15 зөрчил	35.2 сая төгрөг	↓ 1 зөрчил	↓ 13.5 сая төгрөг
ЗАЛРУУЛГА	34 алдаа	413.5 сая төгрөг	↑ 35 алдаа	↓ 342.2 сая төгрөг
АЛБАН ШААРДЛАГА	96 зөрчил	3,372.5 сая төгрөг	↓ 64 зөрчил	↑ 8,005.8 сая төгрөг



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЗӨРЧИЛ ИЛРЭЭГҮЙ БАЙГУУЛЛАГУУД (ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАР)

Арвайхээр сумын 1-р цэцэрлэг

Арвайхээр сумын 4-р цэцэрлэг

Арвайхээр сумын 7-р цэцэрлэг

Арвайхээр сумын 10-р цэцэрлэг

Арвайхээр сумын 13-р цэцэрлэг

Бат-Өлзий сумын 3-р цэцэрлэг

Баянгол сумын цэцэрлэг

Бүрд сумын цэцэрлэг

Богд сумын 2-р сургууль

Есөнзүйл сумын цэцэрлэг

Тарагт сумын цэцэрлэг

Уянга сумын 2-р цэцэрлэг

Уянга сумын
Жаргалант багийн цэцэрлэг

Нарийнтээл сумын
Баянтээг багийн цэцэрлэг

Хархорин сумын 4-р цэцэрлэг

Хархорин сумын 5-р цэцэрлэг



ᠠᠨᠬᠠᠭᠠᠷᠠᠯ
ᠬᠠᠨᠳᠤᠭᠤᠯᠰᠠᠨᠳᠤ



ᠠᠨᠬᠠᠭᠠᠷᠠᠯ
ᠬᠠᠨᠳᠤᠭᠤᠯᠰᠠᠨᠳᠤ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

ТӨРИЙН САНХҮҮ, ТӨСВИЙН ХЯНАЛТЫГ ХАРААТ БУСААР ХЭРЭГЖҮҮЛЖ, ХАРИЛЦАГЧ
ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ИРГЭДИЙН АМЬДРАЛЫГ САЙЖРУУЛНА